

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, “ЦАЙРТ МИНЕРАЛ” ХХК-ТАЙ
1998 ОНЫ 5 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР БАЙГУУЛСАН “ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ГЭРЭЭ”-НД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

Тогтвортой байдлын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү Гэрээг (цаашид “Гэрээ” гэнэ) нэг талаас Монгол улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд, нөгөө талаас “Цайрт Минерал” ХХК (цаашид “Компани” гэнэ) дараах байдлаар харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

1. “Тогтвортой байдлын гэрээ”-ний 2.2-т “Компанийн төлбөл зохих аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг үйлдвэрлэл явуулж эхэлснээс хойш эхний /тав/ 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн /тав/ 5 жилд /тавин/ 50 хувиар хөнгөлнө. Үүнээс цааших хугацааны жилийн татвар ногдох орлого нь /нэг зуун/ 100 сая төгрөгөөс доош бол /арван тав/ 15 хувь, /нэг зуун/ 100 сая төгрөгөөс дээш бол /дөч/ 40 хувиар татвар төлнө.” гэснийг “Компанийн төлбөл зохих аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуульд заасан хувь хэмжээний /тавин/ 50 хувиар /хоёр/ 2 жилийн хугацаанд төлж, үүнээс цааших хугацаанд уг хуульд заасан хувь хэмжээгээр бүрэн төлнө.” гэж өөрчлөх.
2. “Тогтвортой байдлын гэрээ”-ний 2.4-т “Компанийн төлбөл зохих ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын холбогдолтой харилцааг зохицуулж буй хуульд заасан хэмжээгээр тооцно.” гэснийг “Компани нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 2006 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Ашигт малтмалын тухай” хуульд заасны дагуу /тав/ 5 хувиар төлнө.” гэж өөрчлөх.

Энэхүү Гэрээ нь Монгол улсын Засгийн газраас “Цайрт Минерал” ХХК-тай 1998 оны 5 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан “Тогтвортой байдлын гэрээ”-ний салшгүй хэсэг мөн.


Энэхүү Гэрээг 2007 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотноо Монгол, Англи хэлнээ тус бүр /хоёр/ 2 хувь үйлдсэн бөгөөд хувиуд адил хүчинтэй.

Энэхүү Гэрээ нь 2007 оны 8 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:**



**“ЦАЙРТ МИНЕРАЛ” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, “БОРОО ГОУЛД” ХХК-ИЙН ХООРОНД 1998 ОНЫ
7 ДУГААР САРЫН 6-НЫ ӨДӨР БАЙГУУЛСАН “ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ГЭРЭЭ”, 2000
ОНЫ 5 ДУГААР САРЫН 9-НИЙ ӨДӨР БАЙГУУЛСАН “ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН
ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ”-НД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

Тогтвортой байдлын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү Гэрээг нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд, нөгөө талаас “Бороо гоулд” ХХК дараах байдлаар харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

1. “Тогтвортой байдлын гэрээ”-ний 2.2-т “Компанийн төлбөл зохих аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг үйлдвэрлэл явуулж эхэлснээс хойш эхний 3 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлөх, үүнээс цааши хугацааны жилийн татвар ногдох орлогыг 100 000 000 /нэг зуун сая/ төгрөгөөс доош бол 15 хувиар, 100 000 000 төгрөгөөс дээш бол 40 хувиар татвар ногдуулна” гэснийг “Компанийн төлбөл зохих аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 0-3.0 тэрбум төгрөгний албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 3.0 тэрбум төгрөгнөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300.0 сая төгрөг дээр 3.0 тэрбум төгрөгнөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулна” гэж өөрчлөх.
2. “Тогтвортой байдлын гэрээ”-ний 2.4-т “Компанийн төлбөл зохих ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байгаа ашигт малтмалын холбогдолтой харилцааг зохицуулж буй хуульд заасан хэмжээгээр”, 2000 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн “Тогтвортой байдлын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ”-ний 7-т “Тэр нь бүтээгдэхүүний борлуулалтын 2.5 хувьтай тэнцэнэ” гэснийг “Компани нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн Бороогийн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувьтай тэнцүү хэмжээгээр төлнө” гэж өөрчлөх.

Энэхүү гэрээ нь Монгол Улсын Засгийн газар, “Бороо Гоулд” ХХК-ний хооронд 1998 оны 7 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан “Тогтвортой байдлын гэрээ”, 2000 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан “Тогтвортой байдлын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” гэрээний салшгүй хэсэг мөн.

Энэхүү гэрээг 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдөр Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотноо Монгол, Англи хэлээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй.

Энэхүү гэрээ нь гарын үсэг зурагдсан өдрөөс буюу 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:**


САНГИЙН САЙД



Н. БАЯРТСАЙХАН

**“БОРОО ГОУЛД” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

**“БОРОО ГОУЛД” ХХК-ИЙН
ГРӨНХИЙЛӨГЧ БӨГӨӨД
БҮТЭЦЭТГЭХ ЗАХИРАЛ**



ПОВЛА. КОРПИ